

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 02/291  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг “Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны дарга М.Дондогдорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ийн аудитор Г.Бэлэгт хариуцаж хэрэгжүүлэв.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-д 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

#### **Эрхэм зорилго:**

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа” нь Отрын бүс нутгийн бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, нөхөн сэргээх, мал сүргийн байгалийн эрсдэлийг даван туулах чадамжийг нэмэгдүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

#### **Үйл ажиллагааны чиглэл:**

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтыг зохицуулах орон тооны бус зөвлөлийг байгуулж, тухайн жилд аймаг дундын отрын бэлчээрт өвөлжих, хаваржих өрх, малын тоог тогтоож, уг ажлыг зохион байгуулах, бэлчээрийн маргааныг зохицуулах
- Аймаг дундын отрын бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Отрын бэлчээрт барилга, байгууламж, худаг, уст цэгийг барьж байгуулах, засварлах, бүрэн бүтэн байдлыг хадгалах
- Отрын бэлчээрт өвөлжих, хаваржих малчдын нийгмийн хамгааллын асуудалд анхаарч холбогдох арга хэмжээг авах

- Аймаг дундын отрын бэлчээр шинээр байгуулах асуудлыг судалж, санал боловсруулах
- Аймаг дундын отрын бэлчээрт өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Мал амьтан эрүүл мэндийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант онд тухайн байгууллагын мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамтай нийцсэн.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд “Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг шууд гүйцэтгэлээ.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох "Acolous" програм” програм хангамж ашигладаг байна.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогын 1 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь үр дүнгийн тайлан дахь нэмэлт санхүүжилт, хандив тусламжийн орлогын дүн өндөр байгаагаас шалтгаалсан.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны 2018 оны нийт орлого 843,527.2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 8,435.27 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	3,196.6	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
3	Албан шаардлага өгсөн	0	0.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.0	
	Дүн	2	3,196.6	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчил байхгүй болно.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Батлагдсан төсвийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, дотоод хяналтыг сайжруулах.

Анхаарал татсан бусад чухал асуудал байхгүй байна.

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 269,069.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа” нь 2018 онд төсвөөс урсгал зардалд 269,069.8 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөвлөснөөс 268,335.8 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 263,811.3 мянган төгрөгийг зарцуулж, 4,524.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн. Нэмэлт санхүүжилтээр 289,867.3 мянган төгрөг авахаар төсөвлөснийг бүрэн авч гүйцэтгэлээр 243,111.5 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 46,755.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын вэб сайтад шилэн дансны талаар [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд 2018 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн мэдээллийг байршуулсан байна. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа” нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Балансын данстай холбоотой асуудал

##### 1. Илрүүлэлт:

Ажилчдад олгосон нэмэгдэл цалин, хоол унааны хөнгөлөлт зарцуулалтад түүврийн сорил хэрэгжүүлэхэд нэмэгдэл цалинг 850.2 мянган төгрөгөөр илүү, унаа хоолны хөнгөлөлтийг 2,136.4 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй тооцсон байна.

Байгууллагын жижиг мөнгөн сангаас хот дотор явсан шатахууны үнэ 210.0 мянган төгрөгийг ажилчдад олгож, шууд зардалд бичсэн.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

##### 2. Эрсдэл:

Зардлыг эдийн засгийн ангилалын дагуу зарцуулсан эсэх холбогдох хууль тогтоомж, заавар журмыг зөрчсөн байх санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүд зөрчигдөх.

##### 3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

##### 4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмж хүлээн зөвшөөрсөн: Цаашид холбогдох хууль, дүрмийг хэрэгжүүлж ажиллана гэж хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6-р сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайланы

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	64,799,440.00	65,375,310.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33	АВЛАГА	36,067,250.00	43,936,850.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага		43,936,850.00
335	Бусад авлага	36,067,250.00	0.00
3351	Байгууллагаас авах авлага	36,067,250.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	15,000,000.00	0.00
34600	Урьдчилж гарсан зардал	15,000,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,732,190.00	21,438,460.00
354	Хангамжийн материал	13,732,190.00	21,438,460.00
35410	Бичиг хэргийн материал	4,068,540.00	8,169,480.00
35420	Аж ахуйн материал	1,283,500.00	1,405,000.00
35440	Түлш, шатах тослох материал		460,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,380,150.00	11,403,980.00
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,462,329,761.55	3,330,503,080.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,462,329,761.55	3,330,503,080.00
392	Биет хөрөнгө	2,462,329,761.55	2,323,812,728.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,921,869,731.57	19,474,467,65.27
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,067,985,867.76	563,783,887.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	207,661,920.77	315,611,920.77
39204	Хуримтлагдсан элэгдэл	190,501,920.77	216,801,921.57
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	416,915,757.00	417,815,657.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	115,860,079.75	196,831,666.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,357,943.36	25,817,274.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	6,183,127.75	16,336,185.65
39214	Бусад үндсэн хөрөнгө	519,831,487.00	1,282,516,528.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	236,776,082.12	671,641,757.21
393	Биет бус хөрөнгө	0.00	1,006,690,351.60
39301	Програм хангамж	940,170.00	940,170.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	940,170.00	940,170.00
39303	Бусад биет бус хөрөнгө		1,006,690,351.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,527,129,201.55	3,395,878,390.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,527,129,201.55	3,395,878,390.00
51	Засгийн газрын хувь оролцоо	2,527,129,201.55	3,395,878,390.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,526,048,112.68	2,532,738,464.28
51101	Өмч: - төрийн	1,526,048,112.68	2,532,738,464.28
512	Хуримтлагдсан үр дүн	993,821,053.72	753,826,228.25
51210	Өмнөх үеийн үр дүн	1,120,135,933.90	993,821,053.72
51220	Тайлант үеийн үр дүн	-126,314,880.18	-239,994,825.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,260,035.15	109,313,697.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,527,129,201.55	3,395,878,390.00

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	692,545,899.56	843,527,158.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,219,450.00	8,150,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,049,500.00	8,150,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,049,500.00	8,100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,049,500.00	8,100,000.00
120009	Бусад орлого		50000.00
122	Тусламжийн орлого	67,169,950.00	0.00
122002	Хандив тусламж /гадаад/	67,169,950.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	621,326,449.56	835,377,158.11
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	211,547,508.56	268,335,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	211,547,508.56	268,335,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	324,820,750.00	253,800,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	185,235,500.00	112,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	107,600,000.00	141,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,985,250.00	0.00
1330	Төсвийн захирагчдаас	84,958,191.00	313,241,358.11
133003	Хөрөнгийн	84,958,191.00	313,241,358.11
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	818,860,779.74	888,804,395.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	818,860,779.74	888,804,395.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	811,202,207.74	871,495,322.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,389,941.00	126,920,511.00
210101	Үндсэн цалин	96,041,300.00	94,583,211.00
210102	Нэмэгдэл	20,710,500.00	22,993,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,343,600.00	9,343,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,294,541.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,118,500.00	14,037,990.00
210201	Тэтгэврийн даатгал	1,1529,900.00	8,979,689.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,647,200.00	1,311,640.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,317,700.00	998,311.00
210204	Ажилгүйдлийн даатгал	329,500.00	244,579.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,294,200.00	2,503,771.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,893,400.00	1,893,400.00
210304	Байрны түрээс	1,893,400.00	1,893,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,613,477.56	45,728,254.75
210401	Бичиг хэрэг	1,451,560.00	10,295,553.00
210402	Тээвэр, шатахуун	26,820,400.00	33,031,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,329,937.56	1,637,311.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,011,580.00	763,790.00
2105	Нормативт зардал	0.00	5,847,580.00

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны  
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	5,847,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,323,850.00	28,058,327.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	566,460.00	10,879,867.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	40,300.00	5,773,460.00
210604	Урсгал засвар	717,090.00	11,405,000.00
2107	Томилолт, зочны зардал	89,356,800.00	56,075,690.00
210702	Дотоод албан томилолт	89,356,800.00	56,075,690.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,278,148.00	214,249,779.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,935,700.00	212,572,119.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	377,540.00	878,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	580,520.00	556,270.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	84,100.00	77,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,288.00	0.00
210807	Газрын төлбөр		165,790.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	421,228,091.18	378,683,790.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,413,400.00	13,993,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,517,500.00	3,100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	361,297,191.18	361,589,890.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,658,572.00	17,309,073.25
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,950,572.00	9,965,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,050,572.00	2,660,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	7,305,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	708,000.00	7,343,573.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	708,000.00	7,343,573.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-126,314,880.18</u>	<u>-45,277,237.43</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	194,717,588.04
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		194,717,588.04
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-194,717,588.04
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-126,314,880.18</u>	<u>-239,994,825.47</u>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	536,368,258.56	558,501,731.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	211,547,508.56	268,335,800.00
110	Орлогын албан татвар	211,547,508.56	268,335,800.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	211,547,508.56	268,335,800.00
110002	Үйл ажиллагааны орлого	211,547,508.56	268,335,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	50,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	50,000.00
120009	Бусад орлого		50,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	324820750.00	290115931.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	324,820,750.00	289,867,250.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	185,235,500.00	148,067,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	107,600,000.00	141,800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,985,250.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	248,681.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		248,681.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	513,745,158.56	556,006,306.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	513,745,158.56	556,006,306.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	470,019,336.56	494,511,701.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,389,941.00	126,920,511.00
210101	Үндсэн цалин	96,041,300.00	945,83,211.00
210102	Нэмэгдэл	20,710,500.00	22,993,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,343,600.00	9343600.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,294,541.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,118,500.00	14,037,990.00
210201	Тэтгэврийн даатгал	11,529,900.00	8979689.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,647,200.00	1,311,640.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,317,700.00	998,311.00
210204	Ажилгүйдлийн даатгал	329,500.00	244,579.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,294,200.00	2,503,771.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,893,400.00	1,893,400.00
210304	Байрны түрээс	1,893,400.00	1,893,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,604,597.56	49,667,094.75
210401	Бичиг хэрэг	24,04880.00	9,624,493.00
210402	Тээвэр, шатахуун	26,820,400.00	37,401,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,329,937.56	1,637,311.75

“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны  
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,049,380.00	1,003,690.00
2105	Нормативт зардал	874,100.00	5,668,080.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	874,100.00	5,668,080.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,376,700.00	23,045,257.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,891,360.00	10,687,397.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	768,250.00	952,860.00
210604	Урсгал засвар	717,090.00	11,405,000.00
2107	Томилолт, зочны зардал	89,356,800.00	52,165,690.00
210702	Дотоод албан томилолт	89,356,800.00	52,165,690.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,474,398.00	199,249,779.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,131,950.00	197,572,119.00
210803	Даатгалын үйлчилгээ	377,540.00	878,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	580,520.00	556,270.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	84,100.00	77,500.00
210807	Газрын төлбөр	300,288.00	165,790.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,930,900.00	21,863,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,413,400.00	18,763,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,517,500.00	3,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,725,822.00	61,494,604.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,950,572.00	10,214,181.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		248,681.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,050,572.00	2,660,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	7,305,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,775,250.00	51,280,423.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,775,250.00	51,280,423.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	22,623,100.00	2,495,425.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,623,100.00	2,495,425.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,623,100.00	2,495,425.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,623,100.00	2,495,425.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,623,100.00	2,495,425.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-22,623,100.00	-2,495,425.00

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,526,048,112.68	7,260,035.15	1,120,135,933.90	2,653,444,081.73
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,526,048,112.68	7,260,035.15	1,120,135,933.90	2,653,444,081.73
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,526,048,112.68	7,260,035.15	993,821,053.72	2,527,129,201.55
D01	2018 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,526,048,112.68	7,260,035.15	993,821,053.72	2,527,129,201.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,526,048,112.68	7,260,035.15	993,821,053.72	2,527,129,201.55
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	1,006,690,351.60	102,053,662.32	-239,994,825.47	868,749,188.45
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,532,738,464.28	109,313,697.47	753,826,228.25	3,395,878,390.00

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	269,069,800.00	263,811,156.75	5,258,643.25	98.05%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	269,069,800.00	263,811,156.75	5,258,643.25	98.05%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,686,000.00	253,845,656.75	4,840,343.25	98.13%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	127,141,700.00	126,920,511.00	221,189.00	99.83%
210101	Үндсэн цалин	94,805,000.00	94,583,211.00	221,789.00	99.77%
210102	Нэмэгдэл	22,993,200.00	22,993,700.00	-500.00	10.02%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,343,500.00	9,343,600.00	-100.00	1%
2102	Ажил олгогчоос ийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,257,100.00	14,037,990.00	1,219,110.00	92.01%
210201	Тэтгэврийн даатгал	10,171,400.00	8,979,689.00	1,191,711.00	88.28%
210202	Тэтгэмжийн даатгал	1,271,400.00	1,311,640.00	-40,240.00	103.17%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,017,200.00	998,311.00	18,889.00	98.14%
210204	Ажилгүйдлийн даатгал	254,300.00	244,579.00	9,721.00	96.18%
210205	Эрүүл мэндийн аатгал	2,542,800.00	2,503,771.00	39,029.00	98.47%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,893,400.00	1,893,400.00	0.00	100%
210304	Байрны түрээс	1,893,400.00	1,893,400.00	0.00	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	15,978,100.00	15,978,099.75	0.25	0.1%
210401	Бичиг хэрэг	848,300.00	1,278,073.00	-429,773.00	150.66%
210402	Тээвэр, шатахуун	9,917,100.00	9,563,600.00	353,500.00	93.44%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,788,600.00	1,637,311.75	151,288.25	91.54%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,424,100.00	3,499,115.00	-75,015.00	102.19%
2105	Нормативт зардал	734,600.00	723,080.00	11,520.00	98.43%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	734,600.00	723,080.00	11520.00	98.43%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,633,800.00	15,633,257.00	543.00	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,136,600.00	3,275,397.00	861,203.00	79.18%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	570,200.00	952,860.00	-382,660.00	167.11%
210604	Урсгал засвар	10,927,000.00	11,405,000.00	-478,000.00	104.37%
2107	Томилолт, зочны зардал	6,321,300.00	5,294,040.00	1,027,260.00	83.75%
210702	Дотоод албан томилолт	6,321,300.00	5,294,040.00	1,027,260.00	83.75%

**“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны  
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,726,000.00	73,365,279.00	2,360,721.00	96.88%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	73,786,700.00	71,687,619.00	2,099,081.00	97.16%
210803	Даатгалын үйлчилгээ	878,100.00	878,100.00	0.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	630,600.00	556,270.00	74,330.00	88.21%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	84,100.00	77,500.00	6,600.00	92.15%
210807	Газрын төлбөр	346,500.00	165,790.00	180,710.00	47.85%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,383,800.00	9,965,500.00	418,300.00	95.97%
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,383,800.00	9,965,500.00	418,300.00	95.97%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,078,300.00	2,660,000.00	418,300.00	86.41%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,305,500.00	7,305,500.00	0.00	100%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	269,069,800.00	268,335,800.00	734,000.00	99.73%
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	269,069,800.00	268,335,800.00	734,000.00	99.73%
131001	Улсын төсвөөс санхүүжих	269,069,800.00	268,335,800.00	734,000.00	99.73%
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	0.00	100%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100%
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	22.00	20.00	2.00	90.91%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	18.00	2.00	90%
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	0.00	100%
64	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	0.00	0.00	0.00	
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	22.0	20.0	2.00	90.91%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)			0.00	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22.00	20.00	2.00	90.91%

#### 4.6 НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/ төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	289,867,250.00	243,111,470.00	46,755,780.00	87.87%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	289,867,250.00	243,111,470.00	46,755,780.00	83.87%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	289,867,250.00	243,111,470.00	46,755,780.00	83.87%
210401	Бичиг хэрэг	11,555,000.00	8,296,420.00	3,258,580.00	71.80%
210402	Тээвэр, шатахуун	27,838,000.00	27,838,000.00	-	100.00%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,945,000.00	4,945,000.00	-	100.00%
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,412,000.00	7,412,000.00	-	100.00%
210702	Дотоод албан томилолт	54,830,000.00	46,871,650.00	7,958,350.00	85.49%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	148,447,250.00	125,884,500.00	22,562,750.00	84.80%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,740,000.00	18,763,900.00	12,976,100.00	59.12%
210902	Хичээл йлдвэрлэлийн дадлага хийх	3,100,000.00	3,100,000.00	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(289,867,250.00)	(243,111,470.00)	(46,755,780.00)	

#### 4.7 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОХИРУУЛГЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Хөтөл бөрийн код	Зориулалт, арга хэмжээний код	ЭЗ Ангилал 2015	Үзүүлэлт	Тохируулга	Хөрөнгө оруулалт
	80101	131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,755,780.00	
70801	80101	131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,524,463.25	
			<b>Дүн</b>	<b>51,280,243.25</b>	

#### 4.8 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”-ны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	<b>Аудитын код:</b>
2019.02.22			САГ-2019/91/СТА-ТШЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>“Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа”</b>		<b>Мянган төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	3	4	5	9	10
1	Ажиллагсдад олгосон нэмэгдэл цалин, хоол унааны хөнгөлөлтийн түүврийн сорилоорх дүнг ерөнхий журналын дүнтэй тулгахад нэмэгдэл цалин 850.2 мянган төгрөгөөр илүү, унаа хоолны хөнгөлөлтийн дүн 2,136.4 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй тусгагдсан байна. -Байгууллагын жижиг мөнгөн сангаас хот дотор явсан шатахууны үнэ 210.0 мянган төгрөгийг ажилчдад олгож, шууд зардалд бичсэн.	3,196.60	Зөвлөмж өгөх	нягтлан бодогч	Ө.Оюунзул
	<b>Нийт дүн</b>	<b>3,196.60</b>			



